



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/515

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Аймгийн 2019 оны төсөв батлах тухай" 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чөлөөт бөхийн дэлхийн аваргын мөнгө, хүрэл медальт, Монгол улсын "Гавъяат тамирчин" Авирмэдийн Энхээгийн унаган 2 шавь нь 2019 оны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох болсон амжилт бүтээлийг тэмдэглэн цаашдын сургалт, дасгалжуулалтын ажилд дэмжлэг болгон 1.000.000 төгрөг /нэг сая/-ийг хавсралтаар баталж, олгосугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 1.000.000 төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.17 дахь заалтын "Спортын аварга хөтөлбөр"-өөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны  
08 дугаар сарын 08-ны өдрийн  
А/515 дугаар захирамжийн  
хавсралт



ТАМИРЧИДАД ОЛГОХ ХӨРӨНГИЙН  
ЖАГСААЛТ

д/д	Олгох зориулалт	Мөнгөн дүн
1	Сургалт, дасгалжуулалтын үйл ажиллагаанд	1.000.000

-oOo-